

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Сайншанд сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн Б блокын хичээлийн байрны засварын ажил

А. Ажил гүйцэтгэх хугацааны график/ хөдөлмөр зарцуулалт, үргэлжлэх хугацаа, ажиллах хүчний тоо/-ийг тодорхой гаргаж ирүүлнэ. Мөн ажлыг гүйцэтгэх технологи аргачлал, техникийн тодорхойлолтыг боловсруулж ирүүлнэ.

Б. Барилгын их засварын ажлыг дараах Барилгын норм ба дүрэм /БНБД/ стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэх

В. Үнийн саналд зураг төсвийн үнэ 8 700 000 /Найман сая долоон зуун мянга/ төгрөгөөр, зохиогчийн хяналтын зардлыг захиалагчийн хяналтын зардлын 50%-иар тусгаж ирүүлнэ.

Г. Талбайн дотоод зохион байгуулалтын зураг, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг хангах төслийн баримт бичгийг тухайн ажилд нийцүүлэн боловсруулах

Задалж буулгах ажил:

-Сургуулийн барилгын хаалга, цонхыг задалж, шавардлагыг ховхлон унагана. Хуучин будагтай хана, тааз, цоколын ханын гадаргууг 100% хусаж цэвэрлэнэ. Дотор хана таазны суларсан шаврыг бүрэн ховхолж унагана, банзан шал болон керамик хавтанцар шалыг задалж буулгана. Буулгалтын ажлын явцад барилгаас гарсан хог хаягдлыг зориулалтын хогийн цэгт асгана.

Буулгалтын ажил гүйцэтгэх үед хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг чанд мөрдөж ажиллана.

Хаалга, цонхны ажил:

- Хаалга, цонхны ажилд БНБД 81-55-05, MNS 5803:2008 дагуу гүйцэтгэх ба цонхны амалгааны ажилд БНБД 3.04.02-88-г мөрдөнө.

- Цонхыг захиалахдаа талбай дээр нүхний хэмжээг дахин нарийвчлан хэмжих шаардлагатай.

- Сургуулийн барилгын хуучин хаалга, цонхыг бүрэн буулгаж, зураг төсөлд тусгагдсаны дагуу, техникийн тодорхойлолтын шаардлага хангахуйц, сайн чанарын хаалга, цонхыг заагдсан төслийн байриудад тус тус угсарна.

- Цонх хаалганы завсрыг шүршдэг хөөсөөр сайтар битүүмжилсний дараа амалгаа шавардлагыг нямбайлан хийнэ. Мөн хаалганы тотгонд гэгээгч хийнэ. Цонхонд PVC /хуванцар/ тавцан суулгана.

- Хаалга, цонхыг эрх бүхий байгууллагаар хийлгэж угсруулах эсвэл импортын материал худалдан авах тохиолдолд чанартай баг бөхийг сонгон хэрэглэх шаардлагатай.

Шалны ажил:

-Шалны ажилд БНБД 3.04.04-90, БНБД– 81-11-06 мөрдлөг болгоно.

Шалны ажлыг хийж гүйцэтгэхдээ гадаргууг сайтар бэлтгэж тэгшилгээг хийнэ. Хулдаасны залгаа, уулзваруудыг зориулалтын гагнаасаар гагнаж өгнө. Хулдаасыг сонгохдоо 2мм-с багагүй зузаантай эдэлгээ сайн даах, сайн чанарын Солонгос хулдаасыг авч хэрэглэнэ.

Мөн BM100 маркийн бетон дэвсгэр үе дээр 20 мм-ийн зузаан цементэн тэгшилгээ хийсний дараа хэмжилтийн зурагт заасан өрөөний шалны бүтцийн тодорхойлолтын дагуу чулуун хавтан шал, хулдаасан шалыг технологийн дагуу хийнэ. Шал тус бүрт зориулалтын хөвөөг хийж өгнө.

Дотор заслал:

-Барилгын дотор хуурай ба нойтон шавардлага, будаг, шиллэгээ, өнгөлгөөний ажилд БНБД 31-10-05-г мөрдөнө.

-Заслалын ажилд хэрэглэх материалууд нь MNS5252:2003, MNS4584:98, MNS4581:2003 техникийн шаардлагыг хангасан байна.

-Цонх, хаалганы амалгааны засварын ажил БНБД 3.04.02-88-г мөрдөнө.

-Гадна агаарын температур +8 хэмээс багагүй, өрөөний температур +10 хэмээс багагүй үед заслалын ажлыг гүйцэтгэнэ.

-Дотор заслалын ажлыг БНБД 31-10-05-ын дагуу хийж гүйцэтгэнэ.

Хуучин будагтай хана таазны гадаргууг хусаж цэвэрлэж, угсармал хана таазны хөндийрсөн шаврыг ховхолж унагасны дараа сайн чанарын тэгшилгээ хийсний дараа анги танхим, коридорын ханын 2 метрийн түвшинд тосон будгаар будна. Тааз хэсгийг сайн чанарын Солонгос улсад үйлдвэрлэсэн эмульсэн будгаар будна. Шатны гишгүүр, эргэх талбайг гантиг хавтангаар өнгөлж, ариун цэврийн өрөөнд зориулалтын өнгөт хавтангаар /1.4*2м төмөр бэхлэгээтэй/ тусгаарлах хана хийж өгнө. Мөн ариун цэврийн өрөөний таазыг өнгө үзэмж сайтай лампиран хавтангаар хийнэ.

- Тус барилгын хана, тааз, шалны будаг, эмульсийг сонгохдоо хүүхдийн эрүүл ахуйд бүрэн нийцсэн үнэргүй, хар тугалгын орц бага байх шаардлагатайг анхаар.

-Шинээр хийх гантиг чулуун хавтан шал, вааран хавтанцар шал, хулдаасан шал, хаалга, хана, шалны будаг зэргийн өнгөний зохицол хоорондоо тохиромжтой байх бөгөөд өнгө үзэмж, чанар сайтайг сонгон хэрэглэнэ.

- Өрөө тасалгааны өнгөний сонголтыг хийхдээ захиалагч, ашиглагч байгууллагатай харилцан зөвшилцөх шаардлагатай.

Гадна фасадны ажил /А,Б блок нүүрэн тал/:

-Барилгын гадна хана болон цонхны амалгааны хэсгийн хуучин будаг эмульсийг бүрэн хусаж цэвэрлэнэ. Фасадад хэрэглэх будгийг MNS5252:2003 стандартын техникийн шаардлагын дагуу /Солонгос улсын SAMHWA брэндийн гадна эмульсэн будагтай дүйцэхүйц/ чанартай материалыг сонгон хэрэглэх шаардлагатай. Гадна ханыг цемент шохойн зуурмагаар гараар сайн чанартай шавардаж, шавардсан гадаргууд суурь цавуун хөрсжүүлэгч түрхсэний дараа фактуран өнгөлгөө хийж өгнө. Цоколын ханыг дунд ширхэгтэй чулуун өнгөлгөөгөөр өнгөлнө. Цонхонд усны хаялага төмөр хийнэ. Салхины хүч ихтэй тул хаялага төмрийг сайтар бөхөлж өгөхийг анхаар.

-Барилгын гадна саравч, багана, гол орцны саравч, таазны гадаргууд суурь цавуун хөрсжүүлэгч хийж, усан суурьтай эмульсэн будгаар будаж өгнө. Мөн барилгын гадна фасадны дээд ирмэгийн алхан хээг тосон будгаар будвал зохино. Барилгын хуучин

хаяавчны бетоныг бүрэн хуулж хөрсийг сайтар нягтруулсаны дараа шинээр бетон хаяавч цутгаж хийнэ. Бетоны марк БМ-100 байна.

Дотор гэрэлтүүлэг, хүчит төхөөрөмжийн ажил:

-Цахилгааны монтажны угсралтын ажлыг гүйцэтгэх үед БД 43-101-03, БД 43-102-07, БНБД 81-20-04, БНБД 81-30-04 –г мөрдлөг болгоно.

-Дотор цахилгаан тоног төхөөрөмж, кабель утсыг сунгах, утас сүвлэх яндан хоолойг угсрах, шавардлагын доорх далд монтажийн утсыг татаж бэхлэх ажлыг угсралтын ажилтай хамт гүйцэтгэнэ. Цахилгааны ажлыг төсөвт тусгагдсан кабелиар барилгын норм дүрэм стандартын дагуу чанартай хийх шаардлагатай.Цахилгааны холболтын ажилд ППВ-3х4 мм2, ППВ-2х2.5 мм2 маркийн зэс голтой утас хэрэглэнэ. Унтраалга, ризетка нь ус чийгнээс хамгаалагдсан ОХУ-д үйлдвэрлэсэн байна. Зураг төвөст заасны дагуу ЕХИГ бичигтэй цэнэглэдэг гэрэлтүүлэгч, мөн мэдрэгчтэй ослын гэрэлтүүлэгчийг угсарч өгнө.

Дотор халаалт, салхивчийн ажил:

-Халаалт, халуун хүйтэн ус, салхивчийн ажлыг БНБД 3.05.01-88 дагуу гүйцэтгэнэ. Дотор халаалтын шугамыг ган яндангаар угсрах ба халаах яндангийн голч нь Ф20-25мм байна. 50мм бага голчтой халаалтын хоолойнуудыг зориулалтын будгаар будаж өгнө. Мөн бөмбөлгөн хаалт, таслах хаалт, хий авагч болон h-600-900 L-400-3000мм хэмжээтэй панелин радиатор зэргийг зурагт заагдсан төслийн байранд төсөвт тусгасан тоо хэмжээний дагуу угсарч өгнө. Агааржуулалтын сүвгийг задлаж, сүвгийг цэвэрлэнэ. 0.8мм зузаан гөлмөн төмрөөр агаар дамжуулах тэгш өнцөгт огтлолтой 1000мм хүртэл голчтой хоолой угсарч, агааржуулалтын сараалжин торыг байрлуулна.

Дотор цэвэр, бохир усны ажил:

- Усан хангамж, ариутгах татуургын ажлыг БНБД 50-05-98-ын дагуу гүйцэтгэнэ.

-Дотор усан хангамжийн хоолойн голч ф20-25, цэвэр усан хангамжийн хоолойн голч ф25, бохир усан хангамжийн хоолойн голч ф50-100-той байна. Халуун хүйтэн усны шугамыг хөнгөн цагаан голчтой хуванцар хоолойгоор хийж гүйцэтгэвэл зохино.

-Зураг төсөвт заасны дагуу шаазан зайлах торхтой суултуур, хүйтэн, халуун усны салбар шугамтай ганцаарчилсан угаагуур, ханын ганцаарчилсан хөтөвч, агшин зуурын ус халаагч зэргийг тоо хэмжээний дагуу угсарч өгнө.

Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь:

1. Барилгын засварын ажлыг батлагдсан зураг төсөл, ажлын тоо хэмжээний дагуу чанарын өндөр түвшинд, гэрээний хугацаанд багтаан гүйцэтгэнэ.
2. Гэрээнд тусгагдсан бүх ажлыг Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж, БНБД, стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.
3. Барилгын засварын ажлыг эхлүүлэхдээ иргэдийн аюулгүй байдлыг хангуулах зорилгоор анхааруулах тэмдэг тэмдэглэгээ байршуулах, хашаа барих зэрэг шаардлагатай арга хэмжээг авч гэнэтийн аюул осол гаргахгүй байхаар ажиллана.

4. Импортын материал сонгон худалдан авах тохиолдолд тохирлын гэрчилгээ, сертификат, паспорт, лабораторийн шинжилгээний дүнг хавсаргана. Үндэсний үйлдвэрийн материал сонгон авбал Бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ, лабораторийн шинжилгээний дүн, үнийн баримтыг хавсаргана.
5. Барилгын талбайд ажлын журнал, батлагдсан зураг төсөл, хэрэглэгдэж буй материалын лабораторийн сорилтын дүн, тохирлын гэрчилгээ, гарал үүслийн бичиг баримтуудыг бэлэн байлгах шаардлагатай.
6. Барилгын засварын ажлыг чанаргүй гүйцэтгэсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгнө.
7. Барилгын зураг төсөлд зааснаас зайлшгүй тохиолдолд өөрчлөлт оруулах болвол захиалагч болон зураг төслийн байгууллагатай зөвшилцөнө. Зөвшөөрөлгүйгээр газар дээр өөрчлөхийг хориглоно.
8. Барилгын тухай хуулийн 14.3-т заасны дагуу ашиглалтанд хүлээлгэн өгснөөс хойш зүгшрүүлэх, тохируулах хугацаа нэг жил байна. Энэ хуулийн 14.6 заасны дагуу 14.3-т заасан хугацаа дуусгавар болсноос хойш барилга байгууламжийн гадна, дотор засал, бүх төрлийн материал, үндсэн хийц, бүтэц, цэвэр бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны тоног төхөөрөмж тоноглолын хэвийн ашиглалтын хугацаа гурваас доошгүй жил байна.
9. Гүйцэтгэсэн ажлыг ил, далд ажлын акт, схем зураг, фото зургаар баталгаажуулсан байна.
10. Хэрвээ барилгын зураг төсөлд өөрчлөлт оруулах, материал хийц өөрчлөх тохиолдолд хүсэлтээ захиалагч байгууллагад бичгээр гаргаж хүсэлт гаргасан өдрөөс 7 хоногийн дотор хариу өгнө. Зөвшөөрөөгүй тохиолдолд зураг төсвийн дагуу гүйцэтгэнэ.
11. Гүйцэтгэгч нь барилгын ажлын ил, далд ажлын актыг баталгаажуулах, үе шатны ажлын гүйцэтгэлийн тэмдэглэл хөтлөх, барилгын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, зураг төсөл зохиогч, захиалагчаас тавьсан хууль ёсны шаардлагыг бүрэн биелүүлнэ.
12. Энэхүү техникийн тодорхойлолтод заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч, мэргэжлийн хяналтын улсын байцаагч эрхийнхээ дагуу барилгын ажлыг тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй болно.
13. Үнийн саналд Барилга, хот байгуулалтын сайдын 2012 оны 181 тоот тушаалын дагуу нэмэгдэл зардал, төлөвлөгөөт ашиг, техник хяналт, нормчлолын сан, НӨАТ, магадлашгүй ажлын зардал зэргийг тооцож Барилгын төсөв зохиох дүрэм БНБД "ГҮ" 81-95-12-г мөрдлөг болгоно.
14. Үнийн тарифийг тооцон ирүүлэхдээ ажилбар тус бүрээр тооцож ирүүлнэ.

Дорноговь аймгийн Сайншанд сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн Б блокын хичээлийн байрны засварын засварын ажил

А Ж Л Ы Н Т О О Х Э М Ж Э Э

2019/11/04

Д/д	Ажилбарын нэр	Хэмжих нэгж	Тоо
01. Задалж буулгах ажил			
1	Хаалга, цонхны хайрцаг задлах, шавардлагыг ховхлох	ш	78.00
2	Хуучин будагтай ханын гадаргууг 100% хусаж цэвэрлэх	м2	944.76
3	Хуучин будагтай таазны гадаргууг 100% хусаж цэвэрлэх	м2	659.60
4	Цоколын ханын хуучин будагтай гадаргууг 100% хусаж цэвэрлэх	м2	53.86
5	Гадна хана, цоколын суларч хөндийрсөн шаврыг ховхолж унагах	м2	290.64
6	Дотор хана, таазны хөндийрч суларсан шаврыг ховхолж унагах	м2	804.60
7	Гадна ханын хуучин будагтай гадаргууг 100% хусаж цэвэрлэх	м2	585.71
8	Цэвэр ба хар банзан шалны хадаасыг сугалж хуулах	м2	826.76
9	Шалны керамик хавтанцрыг задлаж буулгах	м2	39.44
02. Цонх, хаалганы ажил			
10	2м2 дээш талбайтай давхар шилэн багцтай хуванцар рамтай цонх угсрах	м2	146.12
11	2м2 хүртэл талбайтай давхар шилэн багцтай хуванцар рамтай цонх угсрах	м2	8.64
12	Цонхны зай завсрыг баллонтой шүршдэг хөөсөөр чигжиж дулаалах	м2	154.76
13	Цонх хаалганы амалгаанд шаврын засвар хийх	м2	112.40
14	Цонх хаалганы дотор амалгаанд тэгшилгээ хийж эмүльсэн будгаар будах	м2	112.40
15	Цонхонд PVS /хуванцар/ тавиур суулгах	м2	38.80
16	Дотор хананд 3 м2 хүртэл талбайтай хаалга усрах	м2	14.28
17	Гадна дотор тоосгон хананд 3 м2 дээш талбайтай хаалга усрах	м2	28.35
18	Хаалганд тотгон гэгээгч суулах	ш	9.00
19	Хаалганы зай завсрыг баллонтой шүршдэг хөөсөөр чигжиж дулаалах	м2	46.73
20	Хаалганд цоож суулгах	ш	20.00
03. Шалны ажил			
21	Бегоны дэвсгэр үе хийх БМ100	м3	44.80
22	20 мм зузаан цементэн тэгшилгээ хийх	м2	479.86
23	Хүйтэн гүрхлэг дээр хулдаас нааж шал хийх	м2	479.86
24	Коридоор,вестибюльд цементэн зуурмаг дээр чулуун плитан хавтанцар наах	м2	346.90
25	Цементэн зуурмаг дээр шалны плитан хавтанцар наах	м2	39.44
26	коридоор, вестибюль, ариун нэврийн өрөөний шаланд хавтанцар нааж шалны хөвөө хийх	м	128.70

Дорноговь аймгийн Сайншанд сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн Б блокын хичээлийн ба

Д/д	Ажилбарын нэр	Хэмжих нэгж	Тоо
04. Дотор заслал			
27	Дотор хана таазанд шаврын засварыг цементэн зуурмагаар хийх	м2	804.60
28	Хананд тэгшилгээ хийж сайн чанарын эмульсэн будгаар будах	м2	524.87
29	Анги танхим, коридоорийн хананд тэгшилгээ хийж 2 метрийн түвшинд сайн чанарын тосон будгаар будах	м2	1,049.73
30	Угсармал хавтгаалжин таазанд заслал хийх	м2	834.36
31	Таазанд тэгшилгээ хийж сайн чанарын эмульсэн будгаар будах	м2	834.36
32	Шатны гишгүүр, эргэх талбай гантиг чулуун хавтангаар өнгөлөх 25мм	м2	37.70
33	Ариун цэврийн өрөөнд зориулалтын өнгөт хавтангаар тусгаарлах хана хийх / 1.4х2м төмөр бэхлэлттэй /	м2	34.70
34	Хаалга гаргасан хана битүүлж өрөх	м3	5.75
35	Өрдөг хийсэн ханыг цементэн зуурмагаар гараар сайн чанартай шавардах	м2	30.24
36	Плита наах ханыг цементэн зуурмагаар гараар шавардах	м2	101.60
37	Тоосго бетонон дотор хананд 400х200мм-ийн өнгөлгөөний хавтанцар наах	м2	101.60
38	Ариун цэврийн өрөөний таазанд ламширан хавтан өнгөлгөө хийх	м2	39.44
05. Гадна фасадны ажил /А,Б блок нүүрэн тал/			
39	Нүүр талын тэгш гадаргуу дээр 5м2 талбайтай шаврын засварыг 20мм зузаан цемент шохойн зуурмагаар хийх	м2	251.02
40	Гадна ханын хусаж цэвэрлэсэн гадаргууд суурь навуун хөрсжүүдэгч хийх	м2	836.73
41	Гадна понкны амалгааг цемент шохойн зуурмагаар шавардах	у/м	367.56
42	Шавардсан гадаргууд замагсан тэгшилгээ хийх	м2	947.01
43	Гадна хананд фактуран өнгөлгөө хийх/ шагрей/	м2	836.73
44	Гадна хана сайн чанарын усан эмульсэн будгаар будах	м2	947.01
45	Цонхонд усны халлага төмөр хийх	м2	39.60
46	Гадна цоколын хананд шавардлагын засварыг цементэн шохойн зуурмагаар хийх	м2	37.40
47	Шавардсан гадаргууд замагсан тэгшилгээ хийх	м2	93.47
48	Цоколын хананд дунд ширхэгтэй чулуун өнгөлгөө хийх	м2	93.47
49	Гадна саравч, баганд шавардлагын засварыг 20мм зузаан цементэн шохойн зуурмагаар хийх	м2	33.80
50	Гол орцны саравчинд замагсан тэгшилгээ хийх	м2	56.34
51	Саравчны таазны гадаргууд суурь навуун хөрсжүүдэгч хийх	м2	56.34
52	Гадна саравч усан эмульсэн будгаар гар аргаар будах	м2	56.34
53	Гадна фасадны дээд ирмэгийн алхан хээг тосон будгаар будах	м2	32.40
54	Бетон хаявч цутгаж хийх БМ 100	м3	5.40
55	20 мм зузаан цементэн тэгшилгээ хийх	м2	54.00
56	8м өндөр барилгын борооны усны хоолойг иж бүрнээр нь солих ф-100мм	м	48.50
57	Гадна ханын бусад заслалын ажилд 16 м хүртэл өндөр төмөр шат угсрах ба задлах	м2	583.74
06. Дотор халаалт, салхивч			
58	d=20мм голчтой халаалтын ган яндан угсрах	м	330.00

Дорноговь аймгийн Сайншанд сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн Б блокын хичээлийн ба

Д/д	Ажилбарын нэр	Хэмжих нэгж	Тоо
59	d=25мм голчтой халаалтын ган яндан угсрах	м	110.00
60	Халаалтын яндангийн бэлдэц бэлгэх голч-20мм	м	330.00
61	Халаалтын яндангийн бэлдэц бэлгэх голч-25мм	м	110.00
62	Бөмбөлгөн хаалт угсрах голч d=20мм	ш	38.00
63	Таслах хаалт угсрах голч d=25мм	ш	58.00
64	Хий авагч тавих	ш	38.00
65	Панелин р радиатор угсрах h-600-900 L-400-3000 мм	ш	58.00
66	Халаалтын яндан хоолой усаар шахаж шалгах d=50мм	м	440.00
67	Халаалтын 50мм бага голчтой хоолойнууд будах	м2	39.05
68	Агааржуулалтын сүвгийг задлах	м2	1.92
69	Агааржуулалтын сүвгийг цэвэрлэх	м	36.00
70	Агааржуулалтын сараалжин тор угсрах	ш	32.00
71	0.8 мм зузаан гөлмөн төмрөөр хийсэн агаар дамжуулах тэгш өнцөгт огтлолтой 1000 мм хүртэл голчтой хоолой угсрах	м2	16.20
07. Дотор гэрэлтүүлэг, хүчин төхөөрөмж			
72	10 хүртэл автоматтай гэрэлтүүлэгчийн самбар бэлэн нүхэнд угсрах	ш	2.00
73	1x2.5мм2 хүртэл шиймэл огтлолтой нэг ба олон судастай 1-р утас сүүлгэх	м	1,200.00
74	1x4мм2 хүртэл огтлолтой тэс голтой утас угсрах ПВ660	м	900.00
75	4мм2 хүртэл огтлолтой кабель угсрах ВВГ-660	м	90.00
76	10 мм2 хүртэл огтлолтой кабель угсрах ВВГ-660	м	210.00
77	Лед чийдэнтэй ус чийгнээс хамгаалагдсан гэрэлтүүлэгч таазанд угсрах	ш	104.00
78	"Гарах" бичигтэй хананд тавих цэнэглэдэг батерей бүхий гэрэлтүүлэгч угсрах 20Вт	ш	3.00
79	Хананд тавих цэнэглэдэг батерей бүхий ослын гэрэлтүүлэг угсрах 20 Вт	ком	10.00
80	Хөдөлгөөн мэдрэгчтэй таазны гэрэлтүүлэгч угсрах 60Вт	ш	4.00
81	Тоостой, чийгтэй байранд улайсах ламптай гэрэлтүүлэгч угсрах 60Вт	ширхэг	8.00
82	Хамгаалагдсан хоёр туйлт хоёрлосон унтраалга тавих	ширхэг	26.00
83	Газардуулгын контакттай хамгаалагдсан хоёрлосон розетка угсрах	ширхэг	60.00
84	Ил тавихад газардуулгын контакттай тагтай хамгаалагдсан розетка угсрах	ш	4.00
85	Розетка унтраалагын блок угсрах	ш	90.00
86	Утас салбарлах хайрцаг тавих	ш	20.00
87	Хамгаалалтын гал дэмждэггүй хуванцар хар хоолойг угсрах φ16 мм	м	1,200.00
08. Дотор цэвэр, бохир ус			
88	Дотор ус хангамжийн хөнгөн цагаан голчтой хуванцар хоолой φ 20 мм	м	20.00
89	Дотор ус хангамжийн хөнгөн цагаан голчтой хуванцар хоолой φ 20мм	м	20.00
90	Дотор ус хангамжийн хөнгөн цагаан голчтой хуванцар хоолой φ 25 мм	м	7.00

Дорноговь аймгийн Сайншанд сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн Б блокын хичээлийн ба

Д/д	Ажилбарын нэр	Хэмжих нэгж	Тоо
91	Цэвэр усны яндангийн бэлдэгч бэлтгэх голч-25мм хүртэл	м	47.00
92	Хаалт угсрах голч d=20мм	ш	6.00
93	Бөмбөлгөн хаалт угсрах d=15мм	ком	24.00
94	Шугам хоолой усаар шахаж шалгах d=50мм	м	47.00
95	Бохир усны хуванцар хоолой d-50	м	16.00
96	Бохир усны хуванцар хоолой d-100	м	20.00
97	Хүйтэн, халуун усны салбар шугамтай ганцаарчилсан угаагуур тавих	ш	8.00
98	Шаазан зайлах торхтой суултуур байрлуулах	1ком	8.00
99	Холгич байрлуулах	ш	8.00
100	Ханын ганцаарчилсан хөгөвч тавих	1ш	4.00
101	Агшин зуурын ус халаагч угсрах	ш	2.00
99.Хог хаягдлын дүн			
102	Хог хаягдал	тн	0.00